

Ж.БЕЙКЕРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙГЭЭД "ГУРАВДАХЬ ТҮНШ"-ИЙН АСУУДАЛД

*МУИС, ОУХС-ийн багш,
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин*
Х.Олзвой

АНУ –ын төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкер 1990 оны 7 дугаар сарын сүүл, 8 дугаар сарын шинэдээр Монгол улсад айлчилсан билээ. Энэ үе бол Монгол улсад ардчилсан анхны сонгууль дөнгөж явагдсан, Ирак улс жижигхэн Кувейтийг эзлэн АНУ, өрнөдийн бусад гүрний эдийн засаг, стратегийн ашиг сонирхолд халдаж олон улсын аюулгүй байдал хурцадсан үе байлаа. Манай ард түмний сонгосон ардчиллын замыг батжуулах том гүрнүүд, бусад улсаас дэмжлэг авах, аюулгүй байдал, тусгаар тогтнолоо улам бэхжүүлэхэд "гуравдахь түнш" – тэй болоход энэ айлчлал чухал байлаа.

Ж.Бейкер манай улсад айлчлахынхаа өмнө 1990 оны 7 сарын 13-нд АНУ-д суулгах элчин сайд Г.Нямдоотой уулзаж "... танай сонгууль ямар нэгэн будлиангүй, зохих ёсоор явагдвал би айлчлахад бэлэн байна." гэж онцлон тэмдэглээд будлиан гарвал айлчлах бололцоогүй гэдгээ хэлж байсан билээ (ГХ-ны архив. Фонд № 108, шифр № 53). Гэвч манай улсад явагдсан сонгууль шударга, ардчилсан зарчим дээр, олон улсын ажиглагчдын байлцаатайгаар амжилттай явагдсан билээ.

Бас нэг сонин зүйлийг Ж.Бейкер "Дипломатын бодлого" номондоо (х.6) тэмдэглэсэн байдаг. Тэр нь Ж.Бейкерийн улс төрийн гол зөвлөхүүд, тухайлбал Деннис Росс, Боб Зэллик нар Монголд айлчлуулахгүй, шууд Москвад очихоор зохион байгуулсан байсан юм. Тэд Монголд дургүйдээ биш, хоёр өдрийн өмнө ч гэсэн гэртээ эрт очихыг бодож тэгж төлөвлөж байсан гэж Ж.Бейкер номондоо бичсэн байдаг. Тэгээд Монголд айлчлан ирээд тэр үеийн Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэнгэй уулзахдаа "... хүмүүсийн бодол янз янз юм. Сая намар танай оронд айлчлах тухай ярилцаж эхлэхэд зарим хүн хоёрхон сая хүнтэй Монголд рчих хэрэггүй. Заавал ач холбогдол өгөөд байх шаардлагатай орон биш гэж надад хэлж байсан. Тэр хүмүүстэй би санал нийлээгүй. Манай хоёр орон 70 жил бие биеэ мэдэхгүй, танихгүй хүмүүс шиг явлаа. Бид үүнийгээ одоо цэглэх хэрэгтэй. Ардчиллыг сонгож авсан улс оронтой ойр дотно байх нь бидний сонирхолд нийцэж байгаа юм. Энэ бол бусад улс гүрэнд түгэх тодорхой илгээлт юм шүү" гэж ярьж байсан билээ.

Монголын ерөнхийлөгч П.Очирбатыг уулзах үед /1991.07.26/ АНУ нь ЗХУ, БНХАУ-тай өрсөлдөж Монголд нөлөө олохыг эрмэлзээгүй, Монгол улс шууд хөрш хоёр оронтойгоо "дээд зэргийн" сайн харилцаатай байх нь маш чухал гэж тэмдэглээд ардчилал, чөлөөт зах зээл бол ард түмнүүдийн сайн сайхан байдал, олон улсын тогтвортой байдлыг дээд зэргээр хангадаг гэдэгт АНУ итгэдэг гэж цохон дурдаж байсан юм. Монгол улс Зүүн Европын олонхи улс, тэр тусмаа ЗХУ-тай харьцуулахад зах зээлд амжилттай шинжих, хөгжих илүү бололцоотой

харьцуулахад зах зээлд амжилттай шилжих, хөгжих илүү бололцоотой юм гэсэн санааг ч бас хэлж түүнийгээ батлахын тулд доорхи зүйлүүдийг хэлж байсныг санаж байна. Тухайлбал, Монголд үндэстэн хоорондын зөрчил байхгүй, хоёрхон сая хүнтэй жижиг улс, өөрчлөлт шинэчлэл хийх улс төрийн зориг эрмэлзэлтэй, эдийн засаг нь авсаархан, ХАА-д тулгуурласан орон болж байснаа зах зээлд шилжиж буй Азийн анхны коммунист орон тул Монгол хосгүй шинж чанартай гэсэн байдаг. Харин АНУ геополитикийн болон геостратегийн хувьд Монголд бараг сонирхолгүй гэж тэмдэглэн ярьж байсан билээ. Харин манай улсад туслах, олон улсын тусламжийг нэгтгэн чиглүүлэхийг эрмэлзэхээр ажиллаад Японы тэр үеийн ерөнхий сайд Т.Кайфуг айлчлууулж зовлон, бэрхшээлээ сайн ойлгуулж, ярилцахыг зөвлөж байлаа.

Анхны ерөнхийлөгч П.Очирбат АНУ-тай харилцаа хөгжүүлэх нь Монголд стратегийн ач холбогдолтой, аюулгүй байдлаа улс төрийн аргаар хангах, тусгаар тогтнолоо бэхжүүлэх ач холбогдолтойг тэмдэглэж байжээ.

Ц.Гомбосүрэн сайд ч гэсэн өөрийн улсын гадаад бодлогын бие даасан байдлыг бэхжүүлэх, үүний тулд дэлхийн бүх улс орон, түүний дотор АНУ-тай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд чухал ач холбогдол өгч байгааг онцлон тайлбарлаж байсан билээ. Энэ нь улс орны аюулгүй байдлыг улс төрийн аргаар хангах зорилгоос урган гарч буйг Ж.Бейкерт тодорхой хэлсэн нь олон тулгуурт бодлого баримтлах тухай гадаад бодлогын 1994 онд батлагдсан үзэл баримтлалын нэг гол санааг урьдчилан томъёолсон явдал гэж үзэж болно.

1990 оны айлчлалын үед Сайд нарын Зөвлөлийн дарга асан Ш.Гунгаадорж гуайд Ж.Бейкер бараалхах үед Сайд нарын зөвлөлийн дарга АНУ-тай харилцаа хөгжүүлэх нь зөвхөн цаг хугацааны асуудал биш, алс хэтийн, холын түнш байлгах зорилттой байгааг дурдаад өөрөөр хэлбэл АНУ манай улсын хувьд гуравдахь том түнш бий болж байна гэж хэлэхэд Ж.Бейкер "... би ч мөн иймэрхүү зүйл хэлж байсан. Би энэ тухай хэлэх нь хэлсэн" гэж хариулсан байдаг юм. Тэгээд АНУ-ын нэг зүйр үгийг тухайлбал, "Great minds think alike" ("Аугаа хүмүүс адилхан сэтгэдэг") гэдгийг иш татаж байсныг дурдахад нэн сонин.

Иймэрхүү гуравдахь түншийн асуудал 1910-1920-иод оноос хойш дахин ихээхэн бодитой яригдаж Монголын гадаад бодлогын биеэ даасан, өөрийн эрх ашигт нийцсэн олон шинж төрөхүйц илэрхийлэл болон гарч ирсэн билээ. Энэ нь ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих түүхэн сонголтын үр дүн болсон юм.

Айлчлалын албан ёсны хэсэг бараг дуусч Их Тэнгэрийн амны харшид Ж.Бейкер, түүнийг дагалдан яваа хүмүүсийг хүндэтгэн барьсан оройн зоогны үед ЗХУ-ын гадаад хэргийн сайд Э.А.Швердназе түүнтэй яаралтай ярьж Иракийн түрэмгийллийн тухай хэлэлцэх хүсэлтэй байгааг энэ өгүүллийг зохиогчид хэн нэгэн нь дуулгаж билээ. Зохиогч АНУ-ын Төрийн департаментын хэвлэлийн төлөөлөгч М.Патуайлер, манай эрхэм хуульч Б.Чимэд гуай зэрэг хүмүүстэй хоёрдахь ширээнд сууж байсан бөгөөд Ж.Бейкерт энэ талаар хэлэхийг М.Патуайлераас хүсэхэд өөрөө хэлээч гэсэн сэн. Тэгээд Төрийн нарийн бичгийн дарга

Ж.Бейкер, Ц.Гомбосүрэн сайд нарт миний бие асуудлыг дуулгаж байлаа. Маргааш нь болсон хэвлэлийн бага хурлын өмнө хоёр тал албан ёсны бас нэг уулзалт хийсний дараа ГХЯ-ны коридорт Ц.Гомбосүрэн сайд бидэнтэй дотроо түр зөвлөлдөөд Кувейтийн эсрэг Иракийн хийсэн түрэмгийллийг АНУ, бусад орны адил эрс буруушаан ярихаар шийдвэрлэж Монгол-АНУ-ын дипломатын тэргүүн нарын анхны хамтарсан хэвлэлийн бага хурал дээр түүхэнд анх удаа нэгдсэн байр сууринаас тодорхой мэдэгдэл хийж байсныг дурсан тэмдэглэхэд таатай байна. "Гуравдахь түнш"-ийн тухай үзэл баримтлал гарахын эх ингэж тавигдсаныг тэмдэглэхийн ялдамд нэгэн дурсамж маягийн зүйлээр өгүүлээ өндөрлөө.

Ж.Бейкерийн 1990 онд анх удаа айлчлах үед хоёр талын дипломатын тэргүүн нарын ганцаарчилсан уулзалт хийх тухай шийдвэрлэхэд, түүн дээр юу ярихыг АНУ-тай харилцах асуудлыг эрхэлж байсан Ж.Чойнхор (тэр үед хэлтсийн дарга, одоо АНУ-д суугаа элчин сайд), ажилтан Л. Оргил, хариуцсан орлогч сайд асан миний бие ярилцаад хэдэн зүйл бичиж Ц.Гомбосүрэн сайдад өгсний нэг нь "гуравдахь түнш" бол АНУ мөн гэсэн санаа байсан юм. Сайд ч чухалчлан дэмжиж, харин Ш.Гунгаадорж гуай Засгийн тэргүүний хувьд тодорхой илэрхийлсэн гэж дурсамж өгүүллийг зохиогч одоо ч итгэж явнам.

A part of memoir of late ambassador Kh. Olzvoy who participated in negotiations of Mongolian – American delegations led by Foreign Minister Ts. Gombosuren and State Secretary James Baker in July, 1990. Ambassador recalls remarks by the first president of Mongolia P.Ochirbat and Mongolian Prime Minister of that time about USA becoming the third partner of the country.